



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 109

Улаанбаатар хот

Г “Вүүдсоунд” ХХК-д Хөдөө аж ахуйн Г  
биржийн арилжааны зуучлагчийн  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 10.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор батлагдсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 1.3, 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. “Вүүдсоунд” ХХК-д дор дурьдсан гэрээний төрөл, бараа, түүхий эдийн нэр төрлөөр Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагчийн тусгай зөвшөөрлийг 1 жилийн хугацаагаар олгосугай:

1/ шууд арилжих гэрээ /СПОТ/;

2/ ямааны ноолуур.

2. Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг чанд биелүүлж ажиллахыг “Вүүдсоунд” ХХК /Д.Дамдинсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

000231